

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний
хэрэгжилт, үр дүн

АУДИТЫН КОД: ГСА-2024/18-06-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой
нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудитор:
Б.Сарантуяа, Утас: 70543179
Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр,
Утас: 70543179
Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Дарханбат, Утас: 70543179
Цахим хаяг: darkhanbatb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Дарханбат, Утас: 70543179
Цахим хаяг: ariuntsetsegg@audit.gov.mn

Тайланг бэлтгэсэн:

Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор
Б.Сарантуяа

Аудитын менежер
Г.Наранбаяр

Ахлах аудитор
Б.Дарханбат

Аудитор
Г.Ариунцэцэг

Аудитын тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 70543179
дугаарын утсаар харилцана
уу.

ХАЯГ:

Сүмбэр сум 3-р баг, Нутгийн
удирдлагын ордон, 213 тоот

2024 оны 04 дүгээр сар

Бүлэг-1

Зарим төсөл, арга хэмжээний зураг төсвийг норм, дүрмийн дагуу боловсруулаагүй, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих арга хэмжээг Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд бүрэн тусгаагүй байна. 8

1. А.1.Сүмбэр сумын 150 ортой цэцэрлэгийн барилга, Шивээговь сумын төвийн хатуу хучилттай авто замын ажлын зураг төсвийг норм, дүрмийн дагуу боловсруулаагүй байна.....8
2. А.2.Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг үндэслэлтэй тооцож өөрчлөлт оруулсан бол өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих арга хэмжээг Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд бүрэн тусгаагүй байна.8
3. А.3.Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон байна.....9

Бүлэг-2

Өмнөх оноос дамжин хэрэгжсэн Сүмбэр сумын 150 ортой цэцэрлэгийн барилга, жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилгын ажлыг төлөвлөсөн хугацаанд гүйцэтгүүлж, хүлээн аваагүй байна. 11

4. Б.1 Сүмбэр сумын 150 ортой цэцэрлэгийн барилга, жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилгын ажилд зураг төсөв зохиогчийн хяналт хэрэгжээгүй, төлөвлөсөн хугацаандаа ашиглалтад ороогүй байна.....11
5. Б.2 Улсын комиссын үүрэг даалгаврыг бүрэн биелүүлээгүй байхад ажлыг хүлээн авсан байна.12
6. Б.3 Хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан байна.13

Бүлэг-3

7. Говьсүмбэр аймагт эрх шилжүүлсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ 65.2 хувьтай хэрэгжсэн байна.13
8. В.1 Ашиглалтад хүлээн авсан аймгийн төвийн 2.8 км авто замын ажлыг зориулалтын дагуу ашиглаж байна.13
9. В.2 Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь тэргүүлэх ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангасан ч төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй байна.13

Дүгнэлт

Зөвлөмж

Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал

Шалгагдагч байгууллагын санал тайлбар

Тайлан баталгаажуулах тушаал

Тайлангийн хавсралтууд

ТОВЧИЛСОН ҮГС

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ГА	Гүйцэтгэлийн аудит
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ГСА	Говьсүмбэр аймаг
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗДҮАХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨАГ	Орон нутгийн өмчийн газар
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ҮАХ	Үйл ажиллагааны хөтөлбөр
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс
ХАА	Худалдан авах ажиллагаа
ЭЗНХҮЧ	Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх
үндэслэл,
бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь заалтыг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө, Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх
- Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх

Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
- Авто замын тухай хууль
- “Алсын хараа” 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр
- Засгийн газрын 2021 оны 160, 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам” болон холбогдох бусад аргачлал
- Батлагдсан зураг төсөв, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ, бусад холбогдох эрхзүйн актууд

Аудитын хамарсан
хүрээ:

Аудитад улсын төсвийн хөрөнгө оруулалтыг 2023 онд хэрэгжүүлсэн ТЕЗ болон тэдгээрийн харьяа байгууллагууд аймгийн ЗДТГ, ГХБХБГ, ОНӨГ болон холбогдох бусад гүйцэтгэгч аж ахуй нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, ХАА-ны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагуудаас хяналт хийсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн хүрээнд аудит хийлээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүр төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт боловсрууллаа.

Аудит хийх багийн
бүрэлдэхүүн,
хугацаа:

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дарханбат, аудитор Г.Ариунцэцэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын гүйцэтгэлийн үе шатыг 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс эхлүүлж, тайланг Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан шалгагдагч байгууллага болон холбогдох эрх бүхий албан тушаалтанд 2024 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр хүргүүлээ.

Хүндрэл бэрхшээл:

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд Говьсүмбэр аймагт 46,357.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 11,515.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй шилжих 10 төсөл, арга хэмжээ батлагджээ.

2023 онд батлагдсан төсөл, арга хэмжээний тоо, төсөвт өртгийн хэмжээг өмнөх онтой харьцуулбал:

Он	Шинэ		Шилжих		Нийт	
	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг
2023	0	-	10	46,357.7	10	11,515.2
2022	4	11,856	6	28,662	10	40,518
2021	2	3,700	7	19,414	9	23,114

Хүснэгтээс харахад: Говьсүмбэр аймагт 2023 онд 11,515.2 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээ он дамжин хэрэгжихээр батлагдсан байна.

Төсвийн тухай хуульд нэр зааж батлагдаагүй боловч БОАЖС-ын 2023 оны А/39-р тушаалаар “Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх хөтөлбөр”-өөс “Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд 10 га талбайд байгалийн унаган ашигт ургамал тарьж элсний ургамлын ургамлан бүрхэвчийн талбайг нэмэгдүүлэх” 85.0 сая төгрөгийн ажлын эрх шилжүүлсэн боловч худалдан авах ажиллагааны үр дүнгээр гүйцэтгэгч шалгараагүй амжилтгүй болсон байна.

Тайлант хугацаанд ТЕЗ-ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 4,194.8 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээнээс 4,109.8 сая төгрөгийн 1 төслийг Нээлттэй тендер шалгаруулалт, 85.0 сая төгрөгийн 1 арга хэмжээг харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

Дүрслэл товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Сүмбэр сумын 150 ортой цэцэрлэгийн барилга, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилга	11
Зураг 2	Аймгийн төвийн 2.8 км авто замын ажил /Говьсүмбэр, Сүмбэр сум/	12
Зураг 3	Аймгийн төвийн 2.8 км авто замын ажил /Говьсүмбэр, Сүмбэр сум/	13

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Монгол Улсын 2022, 2023 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан барилга байгууламжийн төсөвт өртөг, санхүүжих дүн	8
Хүснэгт 2	Санхүүжих дүн, төсөвт өртөгт өөрчлөлт оруулсан төсөл, арга хэмжээний жагсаалт	9
Хүснэгт 3	Ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн хэмжээ	10
Хүснэгт 4	Зураг төсөв зохиогчийн хяналтгүй баригдаж буй барилгын судалгаа	11
Хүснэгт 5	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөсөн үр дүн, гүйцэтгэлийн үзүүлэлт	14

БҮЛЭГ 1

Зарим төсөл, арга хэмжээний зураг төсвийг норм, дүрмийн дагуу боловсруулаагүй, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих арга хэмжээг Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд бүрэн тусгаагүй байна.

А.1. Сүмбэр сумын 150 ортой цэцэрлэгийн барилга, Шивээговь сумын төвийн хатуу хучилттай авто замын ажлын зураг төсвийг норм, дүрмийн дагуу боловсруулаагүй байна.

Магадлалаар баталгаажуулсан зураг төсөл, төсөвт дараах шалтгааны улмаас өөрчлөлт оруулах нөхцөл үүссэн байна. Үүнд:

1. Шивээговь сумын төвийн хатуу хучилттай авто зам, 6.9 км авто замын ажил

Шивээговь сумын дотор авто замтай холбогдох хэсэгт өндрийн түвшин зөрүүтэй байгаа нь борооны ус тогтох эрсдэлийг бий болгож байгаа тул захиалагч, гүйцэтгэгч, хяналтын байгууллагууд зөвшилцөн зураг төсөлд өөрчлөлт оруулж түвшний зөрүүг арилгах нэмэлт далангийн ажлыг хийх, өөрчлөлтийн зураг, төсвийг магадлалаар баталгаажуулан улсын төсөвт тусгуулахаар шийдвэрлэжээ.

2. Сүмбэр сумын 150 ортой цэцэрлэгийн өргөтгөлийн барилга-2021 оноос хойш зогсонги байдалд орж ажил удааширсан.

Зураг төсөл, төсвийг Гандирс од ХХК 2015 онд боловсруулж, барилгын хөгжлийн төвөөр магадлал хийлгэн төсөвт өртгийг 1,619.2 сая төгрөгөөр баталгаажуулсан бөгөөд 2019 онд улсын төсөвт 1,619.2 мянган төгрөгөөр батлагджээ.

Уг ажилд 2021 оноос хойш гүйцэтгэл гараагүй тул Улсын Их Хурлын 2021 оны 88 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 75 дугаар тушаалаар “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих барилга, байгууламжийн төсөвт өртгийн өөрчлөлтийг тооцох журам”-ын дагуу бараа материалын үнийн өсөлтийн зөрүүг тооцуулах боломжгүй байна.

Харин захиалагч, гүйцэтгэгч байгууллагууд дараах нөхцөлийг тохирч барилгын ажлыг үргэлжлүүлэх зөвшилцөлд хүрсэн байна.

- Барилгын төсөвт өртөгт цалин хөлсний үнэлгээг Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2009 оны 263 дугаар тушаалаар батлагдсан тарифт цалингаар тооцсоныг шинэчлэх
- Ажлын тоо хэмжээнд өөрчлөлт оруулж гадна хөөсөнцөр фасадыг металл фасадаар солих, тохижилтын ажлыг нэмж зураг төсөл, төсөвт өртөгт өөрчлөлт оруулан магадлалаар баталгаажуулан улсын төсөвт тусгуулахаар шийдвэрлэжээ.

А.2.Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг үндэслэлтэй тооцож өөрчлөлт оруулсан бол өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих арга хэмжээг Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд бүрэн тусгаагүй байна.

Говьсүмбэр аймагт эрх шилжин хэрэгжиж байгаа 6 ажлаас Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд 5 ажил батлагдсан байна.

Монгол Улсын 2022, 2023 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан барилга байгууламжийн төсөвт өртөг, санхүүжих дүн

Хүснэгт № 1

/сая төгрөгөөр/

ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр	2022		2023	
		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
ХХААХҮС	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/	2,200.0	450.0	2,408.1	258.1

БШУС	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Шивээговь сум, 1 дүгээр баг/	2,200.0	800.0	2,135.7	635.7
ЗТХС	Аймгийн төвийн авто замын ажил /Говьсүмбэр, Сүмбэр сум/	3,300.0	1,000.0	3,283.6	2,283.6
ЗТХС	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 6.9 км /Говьсүмбэр, Шивээговь сум/	5,355.6	200.0	5,337.9	2,051.2
БШУС	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Сүмбэр сум/	1,619.2	296.5	-	-
СоС	Дуу бүжгийн "Боржигин" чуулгын барилга /Говьсүмбэр/	7,609.8	1,390.6	8,261.7	3,483.5
Нийт		22,284.6	4,137.1	21,427.0	8,712.1

(Эх сурвалж: Монгол Улсын 2022, 2023 оны Төсвийн тухай хууль)

Хүснэгтээс харахад: Сүмбэр сумын цэцэрлэгийн барилгын ажилд санхүүжилт батлагдаагүй байна. Тус ажлын гүйцэтгэгч “Түмэн алт” ХХК-тай 1,618.6 сая төгрөгийн гэрээ байгуулснаас гүйцэтгэлээр 1,446.1 сая төгрөгийн санхүүжилт олгож үүнээс 91.2 сая төгрөгийг барьцаа дансанд байршуулжээ.

2023 оны төсөвт санхүүжилт тусгагдаагүй, гүйцэтгэгч байгууллага 2022 оноос хойш гүйцэтгэл гаргаагүйгээс барьцаа дансанд байршуулсан 91.2 сая, гэрээний үлдэгдэл 81.3 сая, нийт 172.5 сая төгрөгийн санхүүжилтийн үлдэгдэлтэй байна.

Тайлант хугацаанд дараах ажлуудын санхүүжих дүн, төсөвт өртөгт өөрчлөлт оруулж, гэрээний дүнгээр Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд баталсан байна. Үүнд:

Хүснэгт №2

/сая төгрөгөөр/

№	Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	2023 оны төсвийн тухай хуульд	Тухайн онд санхүүжих дүн	Гэрээний үнийн дүн	
					Анхны	Сүүлийн
1	XI.1.38	Дуу бүжгийн "Боржигин" чуулгын барилга /Говьсүмбэр/	8,261.7	3,483.5	3,471.0	12,430.3
2	X.1.1.240	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Шивээговь сум, 1 дүгээр баг/	2,135.7	635.7	2,135.7	2,769.3
НИЙТ ДҮН			10,397.4	4,119.2	5,606.7	15,199.6

(Эх сурвалж: Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль, эрх шилжүүлсэн ТАХ-ний дансны хуулга, гэрээ, гүйцэтгэлийн баримт)

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.6¹, Засгийн газрын 2022 оны 72 дугаар тогтоолын дагуу бараа материалын үнийн зөрүүгээр нэмэлт гэрээ байгуулж Шивээговь сумын цэцэрлэгийн төсөвт өртөг 633.6 сая төгрөгөөр нэмэгдэж 2,769.3 сая, Боржигин чуулгын барилгын ажлын үргэлжлэл /дотоод засал, интерьер/ 4,109.8 сая, бараа материалын үнийн өсөлтийн зөрүү 4,168.5 сая, өмнөх оны материалын өсөлтийн зөрүү 651.9 сая, анх батлагдсан төсөв 3,500.0 сая, нийт 12,430.3 сая төгрөг болж төсөвт өртөгт өөрчлөлт орсон байна.

Дээрх төсөвт өртгийн өөрчлөлтүүд нь хууль тогтоомжид заасан нөхцөл, шалгуурт нийцсэн байна.

А.3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон байна.

Орон нутгийн эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын дансаар 5 төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон 8,905.5 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч байгууллага болон барьцаа хөрөнгө дансанд шилжүүлжээ.

Ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн хэмжээ

Хүснэгт № 3

/сая төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн	Өмнө нь олгосон	2023 онд олгосон санхүүжилт	Үүнээс: Барьцаа дансанд байршуулсан	Барилгын ажил гүйцэтгэл
1	2 дугаар багийн гэр хорооллыг цэвэр усны шугамд холбох, Тэрэгтийн эх үүсвэрт өргөх станц, цэвэршүүлэх тоног төхөөрөмж /Говьсүмбэр, Сүмбэр сум/	3,558.4	134.8	3,423.6	134.8	-	100%
2	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Шивээговь сум, 1 дүгээр баг/	2,135.7	635.7	800.0	635.7	-	67%
3	Сургуулийн барилга, 640 суудал /Говьсүмбэр, Сүмбэр сум, 2 дугаар сургууль/	5,946.4	317.0	5,629.4	317.0	-	100%
4	Дуу бүжгийн "Боржигин" чуулгын барилга /Говьсүмбэр/	8,261.7	3,483.5	2,782.5	3,225.2	-	48.5%
5	Аймгийн төвийн авто замын ажил /Говьсүмбэр, Сүмбэр сум/	3,283.6	2,283.6	1,000.0	2,283.6	-	100%
6	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 6.9 км /Говьсүмбэр, Шивээговь сум/	5,337.9	2,051.2	200.0	2,051.2	916.6	17%
7	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/	2,408.1	258.1	1,700.0	258.1	54.2	79%
Нийт		30,931.8	9,163.9	15,535.5	8,905.6	970.8	70.2%

(Эх сурвалж: Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль, эрх шилжүүлсэн ТАХ-ний дансны хуулга, гэрээ, гүйцэтгэлийн баримт)

Хүснэгтээс харахад: Эрх шилжүүлсэн 7 ажилд 8,905.6 сая төгрөгийн санхүүжилт олгож, үүнээс 970.8 сая төгрөгийг Засгийн газрын 2023 оны 456 дугаар тогтоолын дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

2022 онд бараа материалын үнийн өсөлтийн зөрүүг магадлалаар баталгаажуулсан Сүмбэр сумын 2-р сургуулийн барилгад 134.8 сая, 2-р багийн гэр хорооллыг цэвэр бохир усны шугамд холбох, тэрэгтийн эх үүсвэрт өргөх станц барих ажилд 317.0 сая төгрөгийг 2023 оны төсөвт тусган олгосон байна.

БҮЛЭГ Б

Өмнөх оноос дамжин хэрэгжсэн Сүмбэр сумын 150 ортой цэцэрлэгийн барилга, жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилгын ажлыг төлөвлөсөн хугацаанд гүйцэтгүүлж, хүлээн аваагүй байна.

Б.1 Сүмбэр сумын 150 ортой цэцэрлэгийн барилга, жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилгын ажилд зураг төсөв зохиогчийн хяналт хэрэгжээгүй, төлөвлөсөн хугацаандаа ашиглалтад ороогүй байна.

Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.32², 37 дугаар зүйлийн 37.1.5³-т заасны дагуу барилгын ажлыг зураг төсөл, норм норматив, техникийн шаардлагын дагуу баригдаж буй эсэхийг зураг төсөв зохиогчийн хяналтын байгууллага хяналт хэрэгжүүлэх хуулийн зохицуулалттай байна.

Говьсүмбэр аймагт баригдаж буй зарим барилга байгууламжид зураг төсөв зохиогчийн хяналт хэрэгжихгүй байгаагаас зураг төсөл, норм норматив, техникийн шаардлагын дагуу гүйцэтгэж буй эсэхийг баталгаажуулаагүй байна. Энэ нь чанаргүй барилга баригдах эрсдэлийг үүсгэж байна.

Зураг төсөв зохиогчийн хяналтгүй баригдаж буй барилгын судалгаа

Хүснэгт №4

/сая төгрөгөөр/

№	ТАХ-ний нэр	Зохиогчийн хяналт хэрэгжүүлэх байгууллагын нэр	Зохиогч байгуулсан гэрээний дүн	Олгосон					Нийт	Үлдэгдэл	БУА-ын гүйцэтгэл
				2019	2020	2021	2022	2023			
1	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга угсралтын ажил	"Нарлаг хүхий" ХХК	18.4	8.5					8.5	9.9	79.0
2	Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга угсралтын ажил	"Гандирс од" ХХК	13.0	-					-	13.0	84.5
Нийт			31.4	8.5	-	-			8.5	22.9	81.75

(Эх сурвалж: Зураг төсөв зохиогчтой байгуулсан гэрээ, дансны хуулга)

Хүснэгтээс харахад: Барилга угсралтын ажил дунджаар 81.7 хувьтай байхад зураг төсөв зохиогчийн хяналт тавьж ажиллаагүй байна. Зураг №1

² 4.1.32. "зураг төсөл зохиогчийн хяналт" гэж барилгын ажил, зураг төсөл, норм, нормативын баримт бичгийн дагуу гүйцэтгэж байгаа эсэхийг зохиогчоос хянаж байгаа үйл ажиллагааг;

³ 37.1.5. барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах;



Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга
угсралтын ажил 2019-2023

Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга
угсралтын ажил 2019-2023

Сүмбэр сумын 150 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилга, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилгын ажил Төсвийн тухай хуульд заасны дагуу төлөвлөсөн хугацаандаа ашиглалтад ороогүй. Өмнөх аудитаар дээрх зөрчлүүдийг арилгах зөвлөмж өгсөн боловч хэрэгжилт хангалтгүй байгаа тул Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.10⁴-т заасны дагуу албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Бусад 4 барилга байгууламжийн хувьд зураг төсөв зохиогч хяналт хэрэгжүүлж холбогдох зураг төсөл, техникийн шаардлагын дагуу төлөвлөсөн хугацаандаа хэрэгжиж байна.

Б.2 Улсын комиссын үүрэг даалгаврыг бүрэн биелүүлээгүй байхад ажлыг хүлээн авсан байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны А/103 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Алтай рөөд ХХК-иас 2023 оны 11 сарын 01-ний өдөр ирүүлсэн аймгийн төвийн 2.8 км замын барилгын ажлыг ашиглалтад хүлээлгэн өгөх хүсэлтийн дагуу барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах талаар хуралдаж, 2023 оны 11 сарын 24-ний өдрийн ГСА/К-8 дугаар актыг үйлдэж ажлыг хүлээн авсан байна.

Ажлыг хүлээн авах улсын комисс явган болон авто зам, замын тэмдэг, тэмдэглэгээ, ногоон байгууламж, орчны цэвэрлэгээний ажлыг дулааны улиралд гүйцэтгүүлэхээр шийдвэрлэн хүлээн авсан бөгөөд эцсийн санхүүжилтийг бүрэн олгосон байна. Зураг №2



Аймгийн төвийн 2.8 км авто замын ажил /Говьсүмбэр, Сүмбэр сум/

⁴ 4.2.1.10 Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол

Улсын комиссын үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй, комисст ажилласан бүх гишүүд зөвшөөрсөн байх шаардлагыг хангаагүй байхад уг ажлыг хүлээн авсан нь *Засгийн газрын 2021 оны 212-р тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 8 дугаар зүйлийн 8.2.1⁵-т заасныг зөрчсөн байна.*

Иймд хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, дулааны улиралд гүйцэтгэхээр шийдвэрлэсэн явган болон авто замын дутуу хэсгийг гүйцээх, тэмдэг тэмдэглэгээ ажлын тоо хэмжээ, стандартын дагуу байршуулах, ногоон байгууламж, орчны цэвэрлэгээг хийж Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгөх албан шаардлагыг захиалагч буюу аймгийн ЗДТГ-т өгөхөөр шийдвэрлэв.

Б.3 Хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан байна.

2023 онд улсын төсвийн хөрөнгөөр оруулалтаар хэрэгжсэн 1 ажлыг ашиглалтад хүлээн авсан байна. Үүнд:

Аймгийн төвийн 2.8км авто замын ажлыг Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-т гэрээний дүнгээр буюу 3,283.6 сая төгрөгөөр бүртгэж нягтлан бодох бүртгэлд тайлагнасан байна.

БҮЛЭГ В

Говьсүмбэр аймагт эрх шилжүүлсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ 65.2 хувьтай хэрэгжсэн байна.

В.1 Ашиглалтад хүлээн авсан аймгийн төвийн 2.8 км авто замын ажлыг зориулалтын дагуу ашиглаж байна.

Улсын комиссын тавьсан шаардлагын дагуу түр тэмдэг, тэмдэглэгээг байршуулж хөдөлгөөнийг нээсэн байна. Авто болон дугуйн замын хэвтээ тэмдэглэгээг зориулалтын термопластик будгаар хийх, тэмдэг байршуулах, ногоон байгууламжийн ажлыг бүрэн хийснээр ажлын гүйцэтгэл бүрэн хангагдах боломжтой байна. Зураг №3



Аймгийн төвийн 2.8 км авто замын ажил /Говьсүмбэр, Сүмбэр сум/

В.2 Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь тэргүүлэх ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангасан ч төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй байна.

Говьсүмбэр аймагт улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнүүд нь тэргүүлэх ач холбогдолтой, хэрэгцээ шаардлагад үндэслэн төлөвлөгдсөн байна. 2023 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын ажлыг 82 хувьд хүргэхээр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 64 хувьтай хэрэгжсэн байна.

⁵ 8.2.1 барилга байгууламж нь ашиглалтад оруулах шаардлагыг хангасан гэж комиссын бүх гишүүд үзсэн тохиолдолд энэ дүрмийн 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт;

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөсөн үр дүн, гүйцэтгэлийн үзүүлэлт

Хүснэгт №5

/сая төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээний нэр	АЗДУАХ			Говьсүмбэр аймгийг хөгжүүлэх 2023 оны жилийн төлөвлөгөө		
		Заалт	Төлөвлөсөн үр дүн	Гүйцэтгэл	Заалт	Төлөвлөсөн үр дүн	Тухайн жилийн гүйцэтгэл
1	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Сүмбэр сум/	2.3.2	100%	84.5%	2.3.2.	100%	84.5%
2	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 6.9 км /Говьсүмбэр, Шивээговь сум/	3.6.2.	70%	17%	3.6.2.	70%	17%
3	Дуу бүжгийн "Боржигин" чуулгын барилга /Говьсүмбэр/	2.6.2.	70%	48.5%	2.6.2.	70%	48.5%
4	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Шивээговь сум, 1 дүгээр баг/	2.3.2	50%	67.2%	2.3.2.	50%	67.2%
5	Аймгийн төвийн авто замын ажил /Говьсүмбэр, Сүмбэр сум/	3.6.2.	100%	95%	3.6.2.	100%	95%
6	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/	3.3.5.12	100%	79%	3.3.11.	100%	79%
Дундаж хэрэгжилт			82%	65.2%		82%	65.2%

(Эх сурвалж: АЗДТГ-ын ХШҮХ-ийн тайлан-2023, аудитын явцад ХБТХОХ, ГХБХБГ-аас авсан судалгаа)

Улсын төсвөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажил төлөвлөсөн үр дүнд хүрээгүй нь дараах хүчин зүйлсээс шалтгаалжээ.

1. Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Сүмбэр сум/-н барилгын ажлын зураг төсөв нь 2015 онд 1,619.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй магадлалаар баталгаажсан бөгөөд Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуульд 1,619.2 сая төгрөгөөр батлагдсан. Санхүүжилтийн асуудлаас шалтгаалан 2021 оноос хойш ажил зогсонги байдалд орсон нь төлөвлөсөн үр дүнд хүрэхгүй байх шалтгаан болсон байна.
2. Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 6.9 км /Говьсүмбэр, Шивээговь сум/-н ажил 2023 оны 09 дүгээр сарын 25-наас 2023 оны 11 сарын 10-ны өдрийн хооронд гүйцэтгэсэн бөгөөд дулааны улирал дуусаж байхад ажлыг эхлүүлсэн нь төлөвлөсөн үр дүнд хүрэхгүй байх шалтгаан болсон байна.
3. Дуу бүжгийн Боржигин чуулгын барилгын ажилд дотоод интерьер засал чимэглэл, шугам сүлжээний ажилд нэмэлт гэрээ байгуулснаас төсөвт өртөг, ажлын тоо хэмжээ нэмэгдсэн нь нөлөөлжээ.
4. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/-ын ажил гүйцэтгэгчийн үйл ажиллагаа, санхүүгийн чадавхаас шалтгаалан зогссон байна.

Аудитаар өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, улсын комисс нь ажлын тоо хэмжээнээс дутуу гүйцэтгэсэн ажлыг хүлээн авсан зөрчилд 3 албан шаардлага өгсөн.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Бүлэг-1

Зарим төсөл, арга хэмжээний зураг төсвийг норм, дүрмийн дагуу боловсруулаагүй, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих арга хэмжээг Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд бүрэн тусгаагүй байна.

1. Сүмбэр сумын 150 ортой цэцэрлэгийн барилга, Шивээговь сумын төвийн хатуу хучилттай авто замын ажлын зураг төсвийг норм, дүрмийн дагуу боловсруулаагүй байна.
2. Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг үндэслэлтэй тооцож өөрчлөлт оруулсан бол өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих арга хэмжээг Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд бүрэн тусгаагүй байна
3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон байна

Бүлэг-2

10. Өмнөх оноос дамжин хэрэгжсэн Сүмбэр сумын 150 ортой цэцэрлэгийн барилга, жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилгын ажлыг төлөвлөсөн хугацаанд гүйцэтгүүлж, хүлээн аваагүй байна.
11. Сүмбэр сумын 150 ортой цэцэрлэгийн барилга, жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилгын ажилд зураг төсөв зохиогчийн хяналт хэрэгжээгүй, төлөвлөсөн хугацаандаа ашиглалтад ороогүй байна.
12. Улсын комиссын үүрэг даалгаврыг бүрэн биелүүлээгүй байхад ажлыг хүлээн авсан байна
13. Хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан байна.

Бүлэг-3

Говьсүмбэр аймагт эрх шилжүүлсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ 64 хувьтай хэрэгжсэн байна.

1. Ашиглалтад хүлээн авсан аймгийн төвийн 2.8 км авто замын ажлыг зориулалтын дагуу ашиглаж байна.
2. Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь тэргүүлэх ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангасан ч төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй байна.

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
Найрамдал хотхон, Утас/Факс: (976) 7054 3005,
И-мэйл: zdtg.gsa@gmail.com, Вэбсайт: www.govisumber.gov.mn

2024. 04. 19 № 8/460
танай _____-ны № _____-т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Зөвлөмжийн хариу хүргүүлэх тухай

Манай аймагт баригдаж буй “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга”, “5 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга”-ын барилга угсралтын ажлын үлдэгдэл санхүүжилт нь 2023 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгагдаагүй тул тухайн онд барилга угсралтын ажлыг гүйцэтгэх, гүйцэтгэл гаргах боломжгүй нөхцөл байдал үүсч, Төсвийн ерөнхийлөн захирагч болох Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам болон Сангийн яаманд ажлыг үргэлжлүүлэх талаар удаа дараа мэдэгдэж ажилласан.


“Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга”-ын зураг төсвийн гүйцэтгэгч “Гандирс од” ХХК-ний тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан тул зохиогчийн хяналт хэрэгжүүлэх эрхийг “Эл энд эйч констракшн” ХХК-д шилжүүлж, гэрээгээр урьд хийгдсэн ажилд нэгдсэн дүгнэлт гаргах, барилга угсралтын ажил эхлэхэд зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан болно.

Дээрх ажлуудад барилга угсралтын ажлыг эрчимжүүлэх, зураг төсөв зохиогч компаниудын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, барилгын ажлын явцад зураг төсөв зохиогчийн хяналтыг тавиагүй зөрчил илэрч өмнөх аудитаар өгсөн уг зөрчлийг арилгах, зөвлөмжийг хэрэгжүүлэх боломж бүрдээгүй болно.

Иймд барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэхэд баримт бичгийн бүрдлийг сайтар бүрдүүлэн, ажлыг эхлүүлэх болохыг үүгээр мэдэгдэж байна.

Хавсралт ...16...хуудастай.

ОРЛОГЧ ДАРГА



Б.НАРАНБААТАР

4250400148

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Хууль эрх зүйн үндэслэлтэй тайлбар, тайлангийн төсөлд өөрчлөлт оруулах санал ирээгүй тул өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн.